

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 20 2023 оны 6-р сар

САЛХИТЫН МӨНГӨ, АЛТНЫ ОРДЫН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙГ КАНАД УЛСЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХУРАЛД ТАНИЛЦУУЛАА

Канад улсын Газар хамгаалалт, нөхөн сэргээлтийн нийгэмлэг, Экологийн нөхөн сэргээлтийн нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан RE3 (Reclaim, Restore, Rewild) бага хурал тус улсын Квебек мужийн нийслэл Квебек хотноо 2023 оны 6 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд болж өндөрлөлөө. Тус хуралд Салхитын мөнгө, алтны ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө (ХМТ) боловсруулах жишиг төслийн олон улсын зөвлөх компани болох “Си Пи Пи Энвайронментал” корпорацийн байгаль орчны ахлах зөвлөх Рэйчел Нобл-Паттинсон оролцож, жишиг төслийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлуудаас танилцуулав. Хуралд үйлдвэрлэл, байгаль орчны нөхөн сэргээлт, экологийн нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаачид, зөвлөхүүд, үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл оролцов. Оролцогчид экосистемийн төрлүүдийг нөхөн сэргээх, хамгаалах, дахин нутагшуулах хамгийн сүүлийн үеийн арга техник, туршлагаадаас танилцуулан, өөр хоорондоо санал солилцож, эдгээр экосистем, олон төрлийн газар ашиглалтын талаарх ойлголт, шинжлэх ухаанд суурилсан менежментийг сурталчлан таниуллаа.

Рэйчел Нобл-Паттинсон хурлын салбар хуралдаан болох “Уул уурхай ба уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл” зөвлөгөөний үеэр “Монгол улс: Уурхайн хаалтын шинэ стандартыг тогтоох нь” сэдвийн дор Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийг танилцуулав. Тэрбээр илтгэлдээ жишиг төслийн хүрээнд зохион байгуулсан чадавх бэхжүүлэх сургалтууд, түүний ач холбогдол, оролцогч талууд, ард иргэдийн оролцоог хангахад чиглэж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хуваалцсанаас гадна жишиг төсөлд уурхайн хаалтын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн туршлагаас иш татжээ. Энэхүү илтгэл нь тус хуралд танилцуулсан олон улсад хэрэгжиж буй цөөхөн төслийн нэг болсон төдийгүй оролцогчид Монголын уул уурхайн салбарын талаар болон иргэдийн оролцоотой холбоотой асуудалд түлхүү анхаарч, лавлан асууж байсныг онцлон тэмдэглэе. Энэ дашрамд хурлын материалыг хамтран элбэгтгэсэн MERIT төслийн байгаль орчны ажилтан Р.Эрдэнэчимэг, ЭСР ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Г.Анх-Амгалан нарт талархал илэрхийлье!

MERIT төслийн хэрэгжүүлж буй уурхайн хаалтын жишиг төслийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох чадавх бэхжүүлэх туршлагыг олон улсын томоохон хуралд танилцуулснаар Монгол улсын уул уурхайн салбарт авч хэрэгжүүлж буй хууль эрх зүйн шинэчлэл, туршлагыг дэлхий дахинд таниулах нэг гарц боллоо.



Зураг 1: Канадын Квебек мужийн нийслэл Квебек хотод болсон RE3 (Reclaim, Restore, Rewild) бага хуралд “Си Пи Пи Энвайронментал” корпорацийн байгаль орчны ахлах зөвлөх Рэйчел Нобл-Паттинсон оролцож, жишиг төслийн талаар танилцуулав.

“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” ИРГЭДИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: САЛХИТЫН МӨНГӨ, АЛТНЫ ОРДЫН ХМТ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСӨЛ

Жишиг төслийн хүрээнд иргэдэд мэдээлэл өгөх гурав дахь удаагийн хэлэлцүүлгийг 2023 оны 6 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Дундговь аймгийн төв Мандалговь хотод амжилттай зохион байгууллаа. MERIT төслөөс “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, Дундговь аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан энэхүү арга хэмжээ нь Салхитын мөнгө, алтны ордын ХМТ-г ард иргэдэд танилцуулах, хаалтын үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй оролцуулах зорилготой юм. Хоёр өдөр үргэлжилсэн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр 150 гаруй иргэн төслийн үндэсний зөвлөх багуудтай ганцаарчлан уулзаж, мэдээлэл авч, 15-30 минутын турш харилцан ярилцаж, санал солилцов. Энэхүү арга хэмжээнд хоёр өдрийн турш давхардсан тоогоор нийт 1200 орчим иргэд залуус оролцож, ХМТ-ний талаар ерөнхий мэдээлэл авч, видео танилцуулга, илтгэлээр дамжуулан мэдлэг мэдээлэл олж авлаа. Иргэдийн идэвх оролцоо Салхитын уурхайн хаалтын асуудал олны анхаарлын төвд буйг харуулж байна.

Зорилго: Тогтвортой ирээдүйн төлөө иргэдийг чадавхжуулах нь

Энэхүү арга хэмжээний гол зорилго нь Дундговь аймгийн иргэдэд Салхитын уурхайн ХМТ болон нөхөн сэргээлтийн ажлын талаар ард иргэдэд мэдээлэл өгөхөд чиглэсэн билээ. Жишиг төсөл орон нутгийн иргэдийг мэдлэг мэдээллээр хангаснаар, хаалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хаалтын менежментийн хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг нэмэгдүүлж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ойлгоход тус дөхөм болно.



Зураг 2: Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр Байгаль орчин, нөхөн сэргээлтийн зөвлөх баг иргэдтэй ярилцан, мэдээлэл өгч буй нь.

Мэдээллийн асар: Санал бодлоо илэрхийлэх, санаа зовнисон асуудлаараа тодруулга авах, харилцан ярилцах платформ
Уг арга хэмжээний үеэр жишиг төслийн үндэсний зөвлөх, мэргэжилтнүүд мэдээллийн асруудад байрлан, иргэдэд уурхайн хаалттай холбоотой дараах сэдвүүдээр мэдээлэл өгч, иргэдийн сонирхсон асуултад хариуллаа. Үүнд:

1. Салхитын уурхайн техникийн нөхөн сэргээлт, газар хэлбэршүүлэлтийн төлөвлөгөө,
2. Салхитын уурхайн биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө,
3. Хаалтын үеийн нийгэм, эдийн засгийн шилжилтийн төлөвлөгөө,
4. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө,
5. Хаалтын болон нөхөн сэргээлтийн өртөг зардлын тооцоо,
6. Уурхайн хаалтын хууль, эрх зүйн шаардлага.

Энэхүү мэдээлэл солилцох өдөрлөг нь харилцан итгэлцлийг бий болгож, иргэд Салхитын уурхайн хаалтын ирээдүйг тодорхойлоход дуу хоолойгоо хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн юм.

■ САЛХИТЫН МӨНГӨ, АЛТНЫ ОРДЫН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ “ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-Д ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЁСЛОЛ

Салхитын мөнгө, алтны ордын ХМТ боловсруулах жишиг төсөл нь нэг жил, есөн сарын хугацаанд олон талт хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжиж дууслаа. 2023 оны 7 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд “Салхитын мөнгө, алтны ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө”-г Эрдэнэс Силвер Ресурс ХХК, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) болон салбарын оролцогч талуудад хүлээлгэн өгөх юм.

Чуулганы эхний өдөр “Салхитын мөнгө, алтны ордын ХМТ болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-д албан ёсоор хүлээлгэн өгөх ёслол болно. Уг төслийг бодлогоор дэмжин ажилласан УУХҮЯ, БОАЖЯ нь уурхайн хаалтын хэрэгжилтийг дэмжиж, сайн туршлагыг уул уурхайн салбарынхантай хуваалцана. Чуулганы хоёр дахь өдөр ХМТ-г хэрэгжүүлэхэд харилцан ойлголцлыг бий болгох зорилгоор илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Энэхүү жишиг төсөл нь Монгол улсад уурхайн хаалтыг оновчтой төлөвлөх стандарт жишгийг тогтоох зорилготойгоор хэрэгжлээ. Төслийн үр дүнд уул уурхайн ижил төстэй төсөл хэрэгжүүлэгчдэд жишиг болохуйц уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж, Монголын уул уурхайн салбарын үйл ажиллагаанд илүү тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах нэг чухал алхам боллоо.

ХОЛБОО БАРИХ

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал
Р.Алтангэрэлтэй имэйл хаягаар холбогдоно уу.
r.altangerel@merit.mn